

БАРГА, ХАМНИГАН, БУРИАДЫН УГСАА-ТҮҮХИЙН ХАМААДЛЫН ЗАРИМ АСУУДАЛД*

Г.ЦЭРЭНХАНД, О.БАТТУЯА

МУИ С, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Угсаатан судлалын тэнхим

Түлхүүр үгс: уг гарлын тууж, буриад, барга, хамниган, омог, Баргужин

ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ. Тус өгүүлэлд Монгол Улсын зүүн бүсэд голлон суугч барга, хамниган, буриадын түүхэн овог /омог/, нутагшил хийгээд ахуй соёлын зарим талыг нь харьцуулан үзэж, барга ба буриадын салсан, буриад ба хамнигадын бие биедээ уусан адилсах болсон цаг үе, хамаадлыг тодруулахыг оролдсон болно.

Аливаа улс үндэстэн бие даан оршихдоо өөр хоорондоо төстэй хийгээд ялгаатай угсаа бүлгээс бүрдэж байдаг билээ. Энэ байдал нь тухайн угсаа нийтлэгүүд хэдийгээр өөр хоорондоо харийн гэгдэх боловч ойр хөрш явснаас юмуу эсвэл угсаа гарал нэгтэй ч түүхэн хөгжлийн явцад алслан нутаглаж байснаас голлон хамаарах ажээ. Үүний жишээ бол, тус улсын зүүн бүс нутагт бөөнөөр суурьших Буриад, Барга, Хамнигад юм. Бид энэхүү өгүүлэлд Дорнод аймгийн Гурванзагал, Хөлөнбуйр сумын “барга”, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо, Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Дадал сумын “буриад”, Биндэр, Дадал, Цагаан-Овоо, Баян-Уул сумын “хамнигад”-ын түүхэн холбогдлын тухайд авч үзлээ.

Буриадын уг гарлын талаар өгүүлсэн ХҮIII-XIX зууны сурвалжуудад /буриадын уг язгуур, түүхийн тухай нийт 11 туужийг эмхлэн “Буриадын түүх бичиг” нэртэйгээр 1992 онд хэвлэсэн/ : буриадыг – “хорь”, “хорь буриад”, “ага буриад”, “баргажин буриад”, “буриад-монгол”, “монгол буриад”; баргыг - “аба - хорчин”, “хорчид”, “барга монгол”; хамниганыг – “15 эцгийн хамниган”, “буриад болсон хамниган”, “хамниган” гэх зэргээр тэмдэглэсэн байх нь нэгэн захиргаанд хамжигдаж байсан, нутагшиж буй газраар нь оноож нэрлэсэн, Ойрад, Халхаас дүрвэж очсоноос шалтгаалж, мөн аман түүхээр уламжлагдахдаа өөрчлөгдсөн зэргээс шалтгаалжээ. Бид угсаа нэр зүйн тухайд дэлгэрүүлэлгүй “барга”, “буриад”, “хамниган”-ы угсаа - хамаадлыг тэдний нутагшил болон омгийн бүтэц, ёс заншлын зарим адил төстэй талд нь тулгуурлан тодруулахыг оролдлоо.

Өгүүлж буй “овог” нь 1925 онд эцгийн нэрийг овог гэж ойлгохыг таниулсан агуулгаар хэрэглэгдэж заншаад эдүгээ нийтэд түгээд буй нэршил юм. Монгол

орны зүүн хойд хэсгээр суурьшигч хамниган, буриад нар “овог”-ийг “эцэг” гэж нэршиж байгаагаар Угсаатан судлалын атласт тусгагджээ (Ринчен, 1979, 45). Энэ нь буриадын дээд уг гарвалаа домоглон өгүүлдэг Хорийн 11 эцэгтэй холбож хэлсэн нь бололтой. Бидний 2002-2003 онд явуулсан судалгаагаар Хэнтий, Дорнод аймгийн буриад, хамнигад ихэнхдээ “омог” хэмээж байна. Иймээс хойно өгүүлэх хэсэгт хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлахдаа тухайн мэдээлэгчийн дамжуулснаар “омог”, мөн сурвалж бүтээлээс ишилснээр “овог” гэхчлэн ялгаатай тэмдэглэсэн билээ.

БАРГА, БУРИАД, ХАМНИГАНЫ ТҮҮХЭН НУТАГШЛЫН ТУХАЙД

Барга, буриад, хамниганы угсаа-түүхийн хамаадалд эртнээс эдүгээг хүртэл айл хөрш нутаглаж ирсэн газар нутгийн байдал зайлшгүй хөндөгдөнө. Тэдний аль алиныг угсаа түүхийн талаар холбогч нутаг бол “Баргужин төхөм” юм. Энэ тухайд баргаар тэргүүлэн авч үзье.

Баеэгү аймаг нь Хүннүгийн үед байсан бөгөөд одоогийн “Барга” юм гэж судлаачид үздэг байна. Хүннү улсын олон аймгийн нэг болох тус Баеэгүгийн тэргүүн нь Баргужин гэж байжээ. VII зууны үед дээрх Баеэгү аймаг нь Хөлөнбуйрын баруун хөвөөгөөр нутаглаж байгаад, IX зууны үед Баргужин төхөм рүү нүүж очсоноос хойш “барга” хэмээн нэрлэгдэх болсон гэж баргын угсаа гарал хийгээд эртний нутагшлыг тодруулсан байдаг (Өлзий, 1992, 3). “МНТ” 8-д: ...Тэд бүлэг иргэн бэр кел Баргужин төхөмийн эзэн Баргудай мэргэний охин Баргужин гуа нэртэй охиныг Хори түмэтийн ноён Хорилардай мэргэнээ өгдөгсөн ажгуу ...Судлаач Пунцаг энд өгүүлж буй Баргудай мэргэнийг буриадын уг гарвалын домогт олонтаа гардаг Барга баатар* мөн гэж үзжээ (Пунцаг, 2000, 109). Баргуд, хори, тулас аймгууд, түмэт аймаг бие биесдээ ойрхон. Сэлэнгэ мөрний нөгөө талд монголчууд нутагладаг. Баргужин төхүм гэж нэрлэдэг газрын яг захад нутаг бууц нь байдаг учир тэднийг баргут гэж нэрлэдэг. Тэдгээр нь тус бүрдээ дарга толгойлогчтой (Рашид - ад - дин., 2002, 82) гэсэн байдгаас үзэхэд Барга баатар буюу Баргудай мэргэн нь Баргужин төхөмөөр нутаглагч барга аймгийн холбооны тэргүүн болох юм. Харин үүнээс арай хожуу үед барга нар хэрхсэн тухайд, бидний онцолж буй сурвалжуудын нэг “Баргажины буриадын түүх бичиг”- т: ...Баргажинд урьд “аба- хорчин” гэж барга монгол ястан сууж

* Буриадын аман домогт: ... монголын хорь түмэт угсаатны Барга баатар дайчин ноёны отгон хүү Хоридой мэргэн, тэрний нэгдэх гэргий Баргажан гуагаас Алан гуа нэрт охин төрсөн гэж өгүүлдэг. /Буриадын түүх бичиг. 1992. 12,35/. Дээрх баримтуудыг ажиглавал зөрөөтэй байдаг тул судлаач А.Пунцаг бичгийн сурвалжид тулгуурласан бололтой.

байгаад, ирээдүй нэгэн цагт энэ нутаг орост эзлэгдэнэ (Баргужиныг 1640-өөд онд Оросууд мэдэлдээ авсан) гэж тухайлаад, Хятад орон руу очиж Хорчидын 20 хошуу нэртэй ард зон болж суужээ. Эд зон эсгий гэртэй, нүүдэлчид, байснаас энд байр суурийн мөр орхилгүй очсон юм. Гэвч хадын горхиноос ус татаж гаргасан суваг, урд цагт эдлүүриж байсан тарианы газрын ул мөр болон газраас олдсон ширэм багаж, сумны зэв мэтийг хорчидийн юм гэлцдэг бөгөөд өнөө тэд Өвөр Монголын Барга аймагт сууж байна (Цэдэвжав, 1887) гэжээ. “Баргужины буриадын эртний түүхэнд хамаатай зарим зүйл”-д тэмдэглэснээр: ... Эрт цагт Баргужин дайдыг эзэлж суудаг хорчид ба барга монголчууд ямар нэг шалтгаанаар нүүж гарахдаа, хорчид нь урагшаа Мон - Гол нутаг руу, баргачуул нь далайн хойно гарч очсон домогтой аж (Сажинов, 1992). Баргужины хамнигад баргуудыг “корчихол” (корч гэдгийг олон тоон дээр нэрлэсэн нь) гэдэг байсан байна. Корчи нь мөнхүү “хорчин”, “хор” нэрээс онцын ялгаагүй, хамниган хэл аялгуунд “х”- г “к”-аар дууддаг. Иймээс энд нутагшиж байсан “аба – хорчин”, “хорчид”, “барга монгол ястан” нь хамнигадын хэлж дадсанаар “корчихол” буюу “корч” байж болох.

Тодруулбал, Баргужинд “баргут”, “аба - хорчин”, “хорчид”, “корчихол” гэх барга монгол угсаа нийтлэг гэмээр соёл нэгтэй хүмүүс эртнээс нааш суурьшиж байсныг монголчуудын бичгийн сурвалж хийгээд буриадын аман түүхээр уламжилсан нь энэ гэлтэй.

Буриадууд Баргужин нутагт суурьшиж байсныг тодруулахын өмнө буриадын уг гарвалын талаар судлаачид болон бидний онцолсон буриад сурвалжид хэрхэн өгүүлснийг дурдъя. Арабын сурвалжид тэмдэглэснээр бол XI-XIII зууны үед Байгаль орчмоор нутаглаж байсан хүн амыг “кури”, “фури” гэдэг байжээ. Эднийг судлаач Г.Н.Румянцев: кури, фури хэмээн арабын сурвалжид дурдагдсан эртний аймаг нь “хори” юм. Дундад зууны үеийн энэхүү “хори”-ийн удам хойч нь өнөөгийн хорь буриадууд байж болох санал дэвшүүлжээ (Дашибалов, 1995, 176). Бидний өмнө өгүүлсэн баргажин буриадын аман түүхэнд дурьдсан баримтууд ч хорийн нутагшилын хувьд энэ саналд түлхэц болохуйц байна.

Буриадуудын дунд өргөн тархсан аман түүхэнд: ... Буриад гэж гарсан язгууртан Байгаль нуурын урд талаар суусан Бэдэ улстай, Бөртэ чонын язгууртай нийлж өнөржиж, урагшаа болон баруун тийш нүүж таржээ. Баргажин нутагт тэдний зарим нь үлдсэний дотор Барга баатрын Буриад, Хоридой хоёр хүү байсан байна. Барга баатрын Буриадай нэрт хүү нь Байгалийн нөгөө талд

гарч, Зүлхэ /Лена/ гэж голд нутаглаж загасны агнуураар амьдарч суув. Нөгөө хүү Хоридой нь язгуур нутагтаа үлдэж 11 хөвгүүдтэй болсон нь хожмын хорийн галзууд, хуасай, хүбдүүд, гушад, шарайд, харгана, бодонгууд, худай, батнай, сагаан, халбин гэх 11 эцгийн сурвалж болжээ гэсэн байдаг. Цааш нь Барга баатрын хүү Буриадайн хоёр хүүгээс гарсан үр сад нь өнөржсөөр убуша, олзон, чоно гэх мэт Эхирэдийн 8 эцэг, алагуй, хурумша, ашабгад зэрэг Булгадын 9 эцгийнхэн болж Эрхүү, Ойхон /Ольхон/ арал, зарим нь Хударийн талд байснаас гадна сүүлд Баргажин, Сэлэнгийн зүүн талаар нутаглаж 6 эцгийнх болон суусан гэжээ (Вандан, 1875; Ширабнимбуу, 1887). ХҮИ зууны дунд үеэс Байгалиас хойших нутгийг оросууд эзэлж эхлэснээр тэндхийн Буриадууд зайлж нүүхээс аргагүй болж Байгальд ойртож, өмнө тийш Эрхүү рүү ирж, зарим нь Баргужинд очиж нутагжсан ажээ.

Бидний хээрийн судалгаанаас үзэхэд Баргужинд сууж хожим “баргажин буриад” гэгдэх болсон буриадын цөөн хэсэг нь одоо Хэнтий аймгийн Дадал, худир буриадууд нь мөн аймгийн Батширээт сумын нутаг, Онон голын зүүн эргээр голлон суурьшиж байхаас гадна орчин үеийн хөгжлийн төвлөрлийг даган зарим нь Улаанбаатар, Багануур дүүрэгт шилжин суурьшжээ. Худир буриадууд нь өөрсдийгөө бид жинхэнэ цэвэр буриад, дээр өгүүлсэн Зүлхэ мөрөнд нутагтай, Эхирэд, Булгадаас гаралтай гэж хэлцэн:

...Өргөн Зүлхээсээ гарахад минь

Өглөө эрт байлаа хэмээн дуулдаг байна. Ононоор суугч эдгээр худир буриадууд нь эхний удаад 1905 оны орчим, үүнээс нилээн хойно 1916 оны орчим хоёрдахиа нүүдэллэн ирсэнтэйгээ нийлээд 50 - 60 орчим өрх болно. Тэдний дунд бөөгийн мөргөл хорь болон бусад буриадуудыг бодвол илүү их дэлгэрсэн байх бөгөөд өөрсдийгөө дархантай, дархан шүтээнтэй гэгцгээдэг (Жавхлан, худир буриадын их чонод омог, 37н, эр, 2003).

XIII зууны үеийн монголын түүхэн сурвалж “МНТ” 239-д: Туулай жил (1207 оны Зүчи баруун гарын цэргүүдээр ойн иргэнд мордуулба. ... Зүчи ойрад, буриад, баргун, урсуд, хабханас*, хангас*, тубасыг оруулаад түмэн хиргисүүдэд хүрбээс ...гээд цааш нь “МНТ” 240-д: ...Бас Борохул ноёныг Хори түмэд иргэнд цагургулба. Түмэд иргэний ноён Дайдухул сохор үхвээс эм нь Ботогой тарган

* Ш.Гаадамбын худам монгол бичгийн эхээр сэргээн хэвлүүлсэн “Монголын нууц товчоо”-г /1990,167/ баримтлан ишилсэн болно. Энд “хабханас”, “хангас” гэснийг академич Ц.Дамдинсүрэнгийн сийрүүлэн хэвлүүлсэн “Монголын нууц товчоо”-д “хабханас”, “ханхас”; Лувсанданзангийн “Алтан товч”-д /1990, 99/ “габганас”, “хабсаг”. А.Амарын “Монголын товч түүх”-д /1989,128/ “булгачин”, “хуриган” гэж тэмдэглэжээ.

түмэд иргэнийг мэдэж ажгуу... (Гаадамба,1990, 167) гэжээ. Эндээс үзэхэд нутагшиж байсан “буриад”, “хори” нь тусдаа сууж байсан төдийгүй нэршлийн хувьд “буриад”, “хори түмэд”, “түмэд” гэхчлэн ялгагдаж байна. “Буриад” ба “хори” (хорь) -ийн энэхүү ангид тусдаа байсан нь өнөө хэр хорь буриадуудын, “баргажин буриад” ба “худир буриад”-ыг өөрсдөөсөө онцолж үзэх бүдэг бадаг ойлголтоор хадгалагдаж иржээ гэж болох юм.

Буриадын аман түүхэнд өгүүлсэнээр, XI-XII зууны үед “буриад” нь Байгалиас баруун ба түүнээс хойш дангаар сууж байсан бол “хорь” (хори) нь мөн үед Баргужин нутагт суурьшиж байжээ. Дээрх баримт, саналуудыг нэгтгээд Байгаль хийгээд Баргужинаар байсан кури (фури)-г, дундад үеийн “хори” аймгийг өнөөгийн хорь буриадын дээдэс гэж болох тухай Г.Н.Румянцевийн саналыг зөвшөөрвөл “хори” ба “буриад” гэж байсны “хори”-д нь баргууд шууд холбогдож хожим хорь, буриад нь түүхэн нөхцөл байдлын улмаас ойртон нэгдэж, харин баргууд тэндээс холдон суусан бололтой. Харин “хори” нь “буриад”-тай нийлэхээс өмнө хаагуур нутаглаж явсныг буриадын аман түүхэнд: ... Буянт сэцэн хааны үед солонгуудын Бүүбэй Бэйл баатарын хүү Дай - Хун тайжид Балжан хатан хадамд өгтөж, инжид нь хорийн 11 овогтон дагаснаар 1600 онд Дай - Хун тайжийн амины албат болжээ. Тэдгээр хорийнхон Эргүнэ голоос эхлэн баруун хойд зүг тийш Онон, Ага, Тура, Энгидэй, Хёлго, Худан, Түгнэ, Үдэ, Итанца болон Байгал хүртэл, Сэлэнгийн баруун гараар, зүүн тийшээ Ярууна, Алс Витим руу суудаг байжээ. Хожим Бүүбэй Бэйл баатар Дай - Хун тайж хүүгээ Ононоос цааш Эргүнэ хүртэл суусан албаттай нь татаж авсанаар, Балжан хатан Ононоос хойш Байгал хүртэл суусан албаттайгаа орхигдсон гэдэг. Түүнээс хойш 1640-өөд оны үед тэгж гээгдсэн хорийнхоны зарим нь Шилкэ, Нерчу голоор нутаглаж байгаад тэндхийн улиад хамнигадад хөнөөгдөж явсан бол нөгөө хэсэг нь Баргажин, Хударын тал, Ойхон арал, Итанцад сууж байжээ. (Төгөлдөр, 1863, Вандан, 1875, Гунга,). Уг сурвалжуудад “хорийн 11 омгийн зон”, “хори 11 эцгийн зон”, “11 эцэг албат зон” гэж ихэвчлэн нэрлэсэн байгаа нь ХҮII зууны үед “хорь буриад” гэх угсаа бүлэг лавтай бүрдээгүй байсны илрэл гэж болох юм. Энэ үед Байгаль орчимын нутаг, Баргужин төхөм нь Монголын нэг хэсэг Сэцэн хэн, Түшээт ханы нутагт багтаж байсан бол Байгалийн өмнөд хэсэг нь ойрад Монголоос хараат байсан байна. ХҮII зууны үеэс эхлэн аажмаар Байгалийн хоёр талын нутаг болон Баргужин төхөм Оросын мэдэлд орж эхлэн яваандаа монголоос таслагдсан нь өнөөгийн буриадын угсаа нийтлэг бүрэлдэх нэгэн үндэс тавигдсан бололтой. Энэхүү хязгаарлалт болон Орос, Хятадын

хооронд хил тогтоосны улмаас зөвхөн буриад, хорь төдийгүй Халх, Ойрадын дайн, Монголын улс төрийн үймээн самуунт байдлаас болж нутгаасаа зайлан нүүсэн халх, ойрадын олон овгууд, хамниган зэрэг угсаа нийтлэгүүдийн оролцоотой угсаатны өөрийн ухамсар тогтворжиж, хорь, ага, баргажин, худир, сонгоол гэсэн тодотгол бүхий өнөөгийн "буриад" нэртэй угсаа - нийтлэг бий болсон нутгийн нэгээхэн хэсэг нь Баргужин нутаг ажээ.

Өнөө үед хамниганыг ихэнх хүмүүс буриадын нэгэн хэсэг гэж үздэгийг буруутгах аргагүй юм. Хамнигад нь өнөөгийн монгол нутагт төдийгүй энд ирж суурьшихаасаа ч өмнө буриадуудтай хөрш амьдарсаар ирсэн нь тэднийг ингэж ойлгоход хүргэснээс гадна ахуй соёлын талаар ч буриад, хамнигад хэдийн адилссан байна. Бид энэ байдалд гол үүрэгтэй газар нутаг болох Баргужиныг хамруулж буй тул энэ тухайд хамниганы байдлыг өгүүлье. Өмнө тэмдэглэснээр "МНТ" 239-д: Зүчи 1207 оны туулай жил ойн иргэнд мордож, ойрад, буриад, баргун, урсуд, хабханас, хангас, тубасыг эзлэн авч түмэн хиргист хүрсэн хэмээсэн байдаг. Үүнийг "буриад", "барга", "хамниган"-ны аль алинд нь холбогдох баримт гэж болохоор байгаа юм. Судлаач Кливез (Тангад, 1996, 335) дээр өгүүлж буй "хабханас" (кабканас) - аас "хамниган" гэдэг нэр үүсэлтэй, энэ хабханас нь өнөөгийн хамниган мөн гэсэн санал дэвшүүлдэг. Харин "хабханас"-тай хамт дурдагдсан "хангас" гэх нэрийг хамнигадын дунд ихэд өргөмжтэй далай гаталж ирсэн дархан "хангис" гэгддэг омогтой хамаатуулж ойлговол сонирхолтой юм. Хамниганы "хангис" омгийнхон одоогоор Хэнтий аймгийн Дадал суманд сууж байна. Тэдний өөрсдийн гарлын тухай өгүүлснийг тодруулбал: Бид хангис омгийнхон төмрийн дархан, дархан удамтай улсууд. Уг нутгаасаа наашлахдаа дөшөөрөө сал хийгээд далай гаталж гарсан өргөмжлөлтэй. Хүний биед гарсан яр түүхийг - далай гаталж ирсэн дархан хангис угтай хүн би, эмч нь бол, домч нь бол гэж цахиж домнодог. Бид 20 гаруй үеийн цаадах баатарын булигаар саадгийг даллагандаа шүтэж ирсэн улс (Зундуйдагва хамниганы "хангис" омог, 2003) гэдэг. Бид хангас (хангис)-ыг хамнигадын хэсэг гэвэл "Монголын нууц товчоо"-д өгүүлсэн нь хамнигад түрэг хэлт угсаа нийтлэгүүд, буриадуудтай эртнээс ойр дөт хамтран суусаар ирсэний нэг баримт болох юм. Баргужинд барга, хамниган, буриадаас хамгийн эрт нь хорь буриадын өвөг дээдэс, баргууд сууж байснаас хойш буриад, хамнигад дараалан ирж суусан ажээ. Баргажины буриадын уг гарлын түүхэнд: ... Урьд цагаас Баргажинд нутагжин суусан хамниган улс шинэ ирсэн буриадуудыг (энэ нь 1740 онд ирэгсдийг хэлжээ) элдвээр газаалдаг (гадуурхдаг), газар ус

булаалдсан хэрүүл шуугиан их болдог, ийм байдлын улмаас буриад, хамнигадын хооронд нутаг зааглан 70 гаруй км урттай хаалт хашаа барьж байсан бөгөөд хамнигад 5-6 мянган хүнтэй байсан...(Цэдэбжав, 1887) гэжээ. Хамнигад эртнээс нааш буриадыг бодвол хүн амын хувьд хамаагүй илүү байсан гэх ба Оросын цагаан хаан хүүхэд нь бага, хүн цөөн гээд буриадын хүн амыг 20 мянга гартал цэрэгт татдаггүй байжээ (Жавхлан худир буриадын “их чонод” омог, 2003). Байгаль орчмоор суурьшиж байсан хамнигад өнөржин олон болоод шинэ газар руу тэлэн нүүх болсны нэг хэсэгт нь бидний өгүүлж буй Баргужин багтжээ. Буриадын түүхэн сурвалжид тодруулсанаар Баргужинд баргуудын дараахан хамнигад ирж суурьшсан нь ХҮИ зууны үед холбогдох юм. Хамнигад шинэ нутгийг ямар аргаар эзлэн суух болсныг : ...Баргужинд суурьшиж байсан баргууд 1600-аад оны ойролцоо өөрөөр хэлбэл оросууд сибир, Байгаль орчмыг эзэлж эхлэхийн үед тэднээс дайжиж зүүн урагш Хятад чигт нүүсэн ...(Цэдэбжав, 1887, Сажинов, 1992) гэсэн бол баргын судлаачийн бүтээлд:... Дээр үед Баргужинд Хорчид Монгол нутаглаж байсныг эвенк (хамниган) нар хөөж гаргасан (Өлзий, 1992, 30) гэх зэргээс үзвэл Баргужинд байсан баргууд түүхэн нөхцөл байдлыг зөв ухаараад оросуудад эзлэгдэхээс өмнө өрсөн нүүсэн үү, хамнигадад хөөгдсөн үү гэдэг нь тодорхойгүй боловч тэдний гарч очсоны хойно манж төрлийн хамнигад ба ортод (ортон) сууриншсан гэдэг нь илэрхий байна.

Дээр өгүүлсэн баримтуудаас харахад өнөөгийн барга, буриад, хамниган хэмээх угсаа нийтлэгүүд нутагшиж төлөвшсөн, тэдний харилцан хамаасах гол газар нь Баргужин төхөм ажээ. Хэдийгээр Баргууд эртний нутгаасаа “буриад” хэмээх өнөөгийн угсаа нийтлэг хэлбэршиж бүрдэхээс өмнө холдсон ч гэлээ барга ба буриадын соёлын зарим талд адил төстэй шинжүүд хадгалагдаж ирсэн нь тэдний түүхэн нутагшлын эртний холбоо хамаарлыг харуулж байгаа хэрэг юм. Мөн барга, буриадын настангууд өөрсдийгөө бид ах дүү, эртний гарал төрөл нэгтэй улсууд гэж одоо ч хуучилдаг (Рэнцэн баргын “гүл улаан” хал, 2003). Харин барга ба буриадын соёлын зарим адил төстэй шинжүүдийг өнөөгийн хорь буриадынхаас илүү тэдний өвөг дээдсийн соёлтой холбож үзэж болмоор байна.

Хамниган ба буриад нь угсаа гарлын хувьд харьд тооцогдох хэдий ч эртнээс нааш хөрш зэргэлдээ суурьшиж ирсний улмаас ахуй соёлын талд харилцан бие биедээ уусч өнгөц байдалд ялгахааргүй болжээ. Германы эрдэмтэн Ф.Ратцелийн:... эд өлгийн соёлын уламжлал нь дүр төрхийн хувьд хэлийг бодвол удаан хугацаанд хадгалагдаж чадна, бас түүний (угсаатны)

тархсан газар нутгийг ч илэрхийлдэг,... нэгэн угсаатны соёл нөгөөдөө шингэх эсвэл нөлөөлөх явдал газар зүйн орчинтой холбоотой (Цэрэнханд, 2001, 181) гэсэн үзэлд холбогдох жишээ болох юм. Гэхдээ хамниган, буриадын адилслыг зөвхөн удаан хугацаанд хөрш суурьшиж ирсэнээр нь шалтгаалцуулж болохгүй. Бидний судалгааны явцад хамнигад, буриадуудтай худ ураг барилдах сонирхолтой байсаар ирсэн бөгөөд хамнигадын өнөөгийн залуучууд заримдаа биеэ буриад гэж тооцох болсон нь тэдний адилсалд газар нутаг төдийгүй тэдний зүгээс буриадтай төслөг байх гэсэн өөрийн ухамсар нөлөөлсөн гэж үзэж болохоор байна. 2002, 2003 онд Хэнтий, Дорнод аймагт хийсэн хээрийн судалгаанаас үзэхэд хамниган, буриад нь хэлний аялгаар хоорондоо ялгагдах боловч нэршлийн хувьд бараг өөрцгүй байж хамнигад нь буриадыг бодвол халх үг аялгаар ярихдаа дадамгай ажээ. Харин баргын настангуудын үг яриа зарим дуудлага, хэллэгээр буриадынхтай адил байх боловч тэдний залуу үе нийтээр халхаар хэлцэж байна.

БАРГА, БУРИАД, ХАМНИГАНЫ ОМГИЙН ХАМААДЛЫН ТУХАЙД

Барга, буриад, хамниган нь газар нутгийн хувьд ойр дөт байснаар бие биедээ адилссан нь тэдний омгийн бүрэлдүүнд ч гэсэн тусгалаа олжээ. Үүнийг хамниганаар тухайлан авч үзвэл, одоогоор бидэнд мэдэгдсэн хамниганы 80 - аад омог байх ба 2002-2003 онд Хэнтий, Дорнод аймгийн нутагт хийсэн хээрийн судалгаагаар табтаан, ноён дулигад, дуулин дулигад, хашха (хашхан), түнгүүс, осрон гэх хамниганы омгууд шинээр бүртгэгдэв. Хамнигадын омгийн бүтцийг 1960-1970-аад оны үед эрдэмтэн Б.Ринчений хийсэн судалгааны бүртгэлд голлон суурилсан бөгөөд зарим омог нь хэлэгдэх аялгууны хувьд дуудлага өөрөөр тэмдэглэгдсэн байх тул давхардсан байж болох юм. 1972 онд хэвлэгдсэн Угсаатны зүйн атласт бидний хээрийн судалгаа явуулсан нутагт хамниганы нийт 30 гаруй омгийн тархацыг тэмдэглэсэн байна (Ринчен, 1979, 46, 51-65, 67, 69, 71).

Буриадын омгуудын үүслийг буриадын уг язгуурын тухай туужуудад, Барга баатрын үр удам Хоридай, Чинуд, Хайдул, Буриадай гэх хөвүүдээс нь өнөржин олон болсон зон гэж домоглосон байдаг. Хорийн 11 эцэг буюу омогт галзууд, шарайд, гучид, хуасай, хөбдүүд, харгана, худай, халибан, бодонгууд, батнай, цагаангууд/ багтана. Хорийн 11 эцэгт багтах эдгээр омгийнхон Байгалийн зүүн хэсгээр нутаглаж ирсэн бөгөөд эднээс галзууд омгийнхон Балжин хатнаас хойш Баргужин төхмөөр голлон сууж байжээ. Харин дээрх Чинуд, Хайдул нар Байгалиас баруун тийш суух болсон Буриадайн араас очиж

тэдэнтэй нийлсэн бөгөөд Чинуд, Хайдул, Буриадайн удмынхан Эхирэдийн 8 эцэг /убуша, олзон, шоно г.м/, Булгадын 9 эцгийнх /алагуй, хурумша, ашабагад г.м /гэгдэж Эрхүү, Ойхон/Ольхон/, Хударын талд нутагжиж байжээ. Тэдний үр удам нь өнөөгийн худир, баргажин буриадууд юм. Баргажин буриадуудын уг гарвалыг баруун боронууд овогтны Тарилан нэрт эр Асуйхан/Алайхан/ гэх удган эхнэртэй байжээ. Үр хүүхэдгүй Булгадай, Эхирэд гэх хөвүүдийг тэжээсний үр удам нь Баргажин буриадууд (Цэжэв,1917) гэж домоглон ярьдаг байна. Бидэнд худир буриадын их чонод, бага чонод, хамнай, хэнгэлдэр, авзайн хөх морьтон, хайтал, бахид, балтай, хурамш, алгууш, дархан галзууд, сэгээнүүд, балтай хайтал гэсэн омгууд бүртгэгдсэнээс авзайн хөх морьтон судалгааны бүтээлүүдэд дурьдагдахгүй байна. Худирын их чонод, бага чонод омгийг чонын (энэ нь дээр өгүүлсэн Чинуд бололтой) 7 хүү буюу догшин долоон зайранаас үүдэлтэй гэж ярьдаг ажээ. Харин тэдний нэгнийх нь хамниган эхнэрээс гарсан хүүгийн үр хойчоос "хамнай" омогтон бий болсон гэдэг (Жавхлан худир буриадын "их чонод" омог, 37н, эр. 2003).

Баргын омгийн тухайд, тэд өөрсдийн омгоо "хал" хэмээн манж үгээр нэрлэдэг. Архивын баримтаас 45, ӨМӨЗО –ны хуучин Барга хошуунд 17, шинэ Барга баруун хошуунд 27, зүүн хошуунд 40, мөн Монголд 1945 онд орж ирсэн 16 баргын хал байгааг бүртгэсэн байна (Цэрэнханд, 1996, 92).

Барга, буриад, хамниганы хамаадлыг омгийн бүтцээр
харьцуулан үзүүлбэл:

Д/д	Буриад	Барга	Хамниган
1	Галзууд	Галзууд	-
2	Шарайд	Шарайд	-
3	Гучид	Гучид	Гучид
4	Харгана	Харгана	-
5	Худай	Худай	-
6	Халбин	Хальвин	Хальбид
7	Бодонгууд	Бодонгууд	Бодонгууд
8	Сартуул	Сартуул	Сартуул
9	Үзөөд	Үзөөн	Үзөөн
10	Хатагин	-	Хатагин
11	-	Отогтон	Отог
12	-	Цоохор	Цоохор
13	-	Чивчин	Чигчин
14	-	Урианхай	Урянхатан
15	Хайтал	Хөх хайтал	-
16	Цонгоол	-	Сонгоол
17	-	Цахар	Цахар

Бидэнд мэдэгдээд байгаа барга, хамниган, буриадын (үүнд баргажин, сонгоол, хорь, ага буриадын омгийг нийтэд нь хамруулсан болно) нийт омгуудын заримыг хооронд нь харьцуулсан хавсралт хүснэгээс үзвэл эдгээрт бүгдэд нь адил давхардаж буй гучид, халибан, бодонгууд, сартуул, үзөөн 5 омог байгаагаас барга ба буриадын аль алинд нь галзууд, шарайд, гучид, харгана, худай, халиван, бодонгууд, сартуул, үзөөн, хайтал гэх 10 омог, хамниган ба буриадад гучид, сартуул, үзөөн, хатагин, халиван, бодонгууд, сонгоол гэх 7 омог, барга ба хамниганд гучид, халибан, бодонгууд, үзөөн, сартуул, отог[тон], цоохор, урианхатан, чигчин, цахар гэх 10 омог адил байх ажээ. Буриад, хамниган, баргад адил байгаа гучид, халибан, бодонгууд омог нь Хоридайн угсааны хорийн 11 эцэгт багтах эртний түүхт омгууд юм.

Энд багтсан гучид омгийг судлаачид: - тооны нэртэй, - ураг төрлийн холбоотой уялдуулж, нэгэн ургийн гуч нар нэгдэж омог болсон байж болох таамаг дэвшүүлсэн байдаг. Хорь буриадын үүслийн тухай домогт Гучид /Гушид/ нь Барга баатрын хүү Хоридойн нэгдэх эхнэр Шаралдайгаас гарч өнөржсөн нь гэжээ.

Халибан омог: Судлаач Г.Н.Румянцев, булгадын нэг салбар болох хангин нь буриадын халибан омог болсон байх гэдэг санал гаргасан байна. Мөн ойрад монголын дотор ураг ураглах, хүү гэрлүүлэх, хүүхэн богтлох хурим тойгын үед хүүхэндээ ёслолын өмсгөлийн нэг "халибан" хэмээх малгай өмсгөдөг байсан ёс заншилтай холбоотой омгийн нэршил үүссэн байж болох юм гэжээ (Батнасан, 1996, 12). Буриадын түүх бичлэгт тэмдэглэснээр бол хамниган, буриадын омгууд өнөржиж хүн ам олон болох тусмаа дотроо салбарлан хуваагддаг байсан аж. Өөрөөр хэлбэл засаг захиргааны нэгжид багтах хүн, өрхийн тоо хэмжээ хэтэрсэн, газар бэлчээрээс хамааран нэг дор олноор нутаглах боломжгүй холдож нүүх болсон зэргээс үүдэн ингэж хуваагдаж явсан бололтой.

Халибан омог дотроо хуригай (буриадын үг хэллэгт "ай" нь хамаатуулах нөхцөлөөр хэрэглэдэх бөгөөд ингэж үзвэл хурига+ай=хуригай эсвэл хуриган+ай=хуригай гэж бүтсэн мэт санагдана), мэнгэй, жирохон, гутаарь халибан гэх мэт салбар омгуудтай.

Бодон омог: Буриадын аман түүхэнд Хоридойн хөвгүүдийн үр хойчисоос энэ омог үүдэлтэй гэхээс гадна, бодон омгийн нэрийн гарал онгон тотемтой холбоотой гэдэг. Энэ нь зэрлэг гахай тотемчилохоос үүдэн бодонгууд /бодон/ хэмээх нэршилтэй омог үүсч гарсан бололтой гэсэн судлаачийн санал юм. Нэрийн утгын тухайд, эрдэмтэн Ш.Гаадамба судалгааныхаа бүтээлд: "Эрдэнийн

эрх"-д, ... Бодунгчар тэрбэр Боданг нэрэтү хатун абчу нэгэн орон-у аймаг-ун нойан болжу... мөн "Хөх дэвтэр"-т, ... удалгүй ирж ах нартай нийлэлдээд ноёнгүй нэг бүлэг улсын аймгийг эрх дороо оруулаад Бөтүн нэрт хатныг авч, тэр аймаг улсыг эзэлж ноён болов... гэснийг ишлэн тэнд өгүүлж буй "Боданг" ба "Бөтүн" гэдэг нэр бол хүний тусгайлсан нэр биш. Энэ бол овгийн толгойлогч анчин баатар эмэгтэйг хэлдэг ерөнхий нэр байсан бололтой гээд цааш нь монголын аман зохиолд "Эзэн улаан бодон", "((Талын)Шар бодон)" гэж олонтаа гарах туульсийн баатрууд нь эр хүний хувцастай баатар анчин эмэгтэй байж болох юм гэжээ (Гаадамба, 1976, 106, 107). Эдгээр жишээг Оросын эрдэмтэн аман зохиол судлаач Е.Мелетинскийн: "Буриадын аман зохиолын нөлөөг үзэхийн хамт, хөгжлийн үлэмж эртний шатыг тусгасан аман зохиол бүхий нанайчуудын дунд эр хүний хувцастай анчин баатар хүүхэн Пудиний үлгэр дэлгэрсэн тухай сонирхууштай мэдээ буй" гэж тэмдэглэсэнтэй холбон тайлбарласан байна. Буриадын аман зохиолын нөлөөг даган нанайчуудын үлгэрт гарах анчин баатар хүүхэн Пүдиний нэр буриадаас уламжилсан байж болох юм. Тэгвэл буриад, барга, хамниганы "бодон" /бодонгууд/ омгийн нэрийг судлаачийн тайлбарласнаар, монголын аман зохиол, сурвалжид тэмдэглэгдсэн "пүдин", "бөтүн", "боданг", "бодон" нэрүүдтэй утга холбон ойлговол сонирхолтой байна.

Сартуул омог : "МНТ" 263-д: Сартуул улсыг эзэлж дуусаад Чингис хааны зарлигаар хот, хотод дарга тавихад Хоромши омогтой Ялавич, Масхуд нар хот газрын ёс заншлын талаар Чингис хаантай ярилцаж, хот газрын заншлыг сайн мэдэх тул хөвүүн Хоромши Масхудыг монгол дарга нарын хамт олон хот захируулаад, эцэг Хоромши Ялавачийг авчирч Хятадын Жунду/Бээжин/ хотыг захируулсан байна. Мөн Хятад улсыг захирах монгол дарга нарын дэргэд сартуул хүмүүсийг зөвлөгчөөр томилж байжээ. Тэд гадна Их Юан улс унаснаар суугуул монголчуудын хамт хятад газраас хөөгдөн язгуур монголд ирж суусны зарим нь Халхын Сэцэн ханы сартуул отог гэж байгаад 1630-аад оны орчим тэргүүн сайд Хүлэг ах дүү хамтаар долуул Оросын мэдлийн Зэдэ, Үнгэй голоор ирж суусан (Бяцхан тэмдэглэл, 19-р зууны үед холбогдоно) нь дээрх сартуул омгийнхон бололтой. Иймээс Чингисийн үеийн сартуул иргэдийн үр хойчис Монголын улс төрийн бутралын үед Байгаль тийш очиж барга, буриад, хамнигадын дотор багтан орсон нь энэ болжээ. Хамнигадын дотор байх сартуул омог нь дотроо баахашил, бамбачаан, буянта, гуринха, гуриг, модоргон, хатагин, шинжэг, махан, кепченүүд, гачинха, бамбадаан гэж ялгагдаж байна

(Ренчиний хувийн архивын баримт, УТА. Ф-32, ХН-12). Энэ нь тус омог их эртний түүхт, нөгөөтэйгүүр харь овог аймгаас ирж тэдэнд нийлж ууссан, мөн биесээ хочлон нэрлэснээс дээрх олон маягаар нэрлэсэн гэдгийг нь харуулж байж болно.

Үзөөн омог: Монгол нутгаас гаралтай омог юм. 1660 оны орчимд Түшээт ханы нутгаас амар жимэр амьдралыг эрхэмлэж оросын цагаан хааны захиргааг дагахаар ирэгсэд ажээ (Бяцхан тэмдэглэл, 19-р зууны үед холбогдоно). Хамниганд гачинха сартуул, баахашил сартуул, модоргон сартуул, бамбачин сартуул, хатагин сартуул гэх омгуудыг хамтад нь 5 эцгийн хамниган гэсэн байхад эднийг тодотгож нэрлэсэн гачинха, баахашил, модоргон, бамбачаан, хатакин хэмээх омгууд хамниганд бие дааж байна. Энэ нь сартуул хамниганы уугуул омог биш гэдгийг давхар нотолно. Барга, буриадын хувьд (хорийн) эртний Хоридойгоос үүсэлтэй гэх омгууд хоорондоо адил буй нь тэдний эртний холбоо сүлбээг харуулж буй юм. Хамниган ба буриадын адил омгуудын тухайд, эртнээс хамт суурьшиж ирсэн тэдний газар нутаг Оросын мэдэлд хамжигдсанаар энэхүү “омог” нь ураг төрлийн гэхээсээ илүү засаг захиргааны зохион байгуулалтын агуулгыг илэрхийлэн, хоорондоо адилсах нөхцөл бий болсон байна. Өөрөөр хэлбэл буриад, хамнигад болон монголоос очсон олон иргэд ХҮИ зууны үеэс оросуудын мэдэлд орж эхлэн засаг захиргаанд хуваагдсанаар, дээрх омгууд нь тэднийг аль нэг захиргаанд хамаарч буйг илэрхийлэх болжээ. Иймээс бид энэ үеийн барга, буриад, хамниганы омгийн хамаадлыг нэгэн угсаа гарлын үүдэлтэй гэхээс илүү хамтдаа нэгэн засаг захиргаанд толгой мэдүүлж явсных гэж ойлгох хэрэгтэй юм. Тэдний дотор буй халибан, бодон, гучид гэх түүхэн омгууд буриадуудын нэрлэж заншсан “эцэг” гэдэгтэй адилтгах ойлголт боловч орчин үед нэгэн омогт багтаж буй хүмүүсийг цусан төрлийн холбоотой төрөл садангууд гэвэл учир дутагдалтай. Харин аман түүх, сурвалжид өгүүлснээр эртний үедээ уг гарлын талаар нэг гэж болох юм. Нөгөөтэйгүүр омог нь тодорхой түүхэн цаг үед отог, овог, омог, эцэг гэгдэж байсан боловч агуулгын хувьд нийгмийн зохион байгуулалтын нэгж болж байсан гэдэг нь хамниган, буриадад холбогдох буриадын түүхэн сурвалжид хангалттай өгүүлсэн байна. Буриад, хамнигадын эртний омгуудын нэрээр хошуу, аймаг, сумыг нэрлэж байсныг МУ-ын 16, 17 оны үед Монголд олноороо ирж суурьшсан буриад, хамнигадын өргөн батлах бичиг, дагаар орсон бүртгэлээс тодорхой мэдэж болно. Жишээ татвал: *Орос улсын харьяат, Хорийн аймаг, Хуасай хошууны, Могзоон сумаас ирсэн Одоны Тэх; Орос улсын харьяат, Агын*

аймгийн Адагалиг хошууны Үзөөн сумаас ирсэн Доржийн Цэмпил ...гээд цааш нь, Өчүүхэн хүмүүн миний бие уг шашин ясны барилдлагыг хүндэтгэн дагаж үүрд тус монгол ах дүү лүгээ нийлэх ба урьд тус газар нүүдэллэн ирж тохнисон өөрийн төрөл садантай хамтрахын үнэн зорилгоор уул нутгаас монголын 16 оны 3 сарын 16-ны үеэр ам хөрөнгийн хамтаар гарч 16 оны 4 сарын 15 өдөр Улхан зэрэг газраар хилийг нэвтрэн орж энэ удаа Цагаанбулаг зэргийн газар сууж буй бөгөөд, уул нутаг захиргааны газраас тус монголын газар нүүдэллэн одохын зөвшөөрөл эс олгогдог учраас үүний урьд нүүдэллэн ирсэн буриад нийтийн заншлыг даган аль ч газрын тавилгагүйгээр уул газраас хил нэвтрэн орсон миний түмэн үнэн бөлгөө... (ҮТА. Ф-92. Д-1. ХН-7) гэх зэргээр Орос улсын нутгаас орж ирсэн дагаар орох хүсэлтэй өрх айлын тэргүүнүүд, давхар батлан даах хүний гар даасан тэмдэглэгтэй Онон голын хорь буриад хошууны тамгын газарт өргөх бичиг барьжээ. Тэднийг ийнхүү монгол нутагт ирсний нэгэн шалтгаан нь угсаа гарлаа эрхэмлэх үзэл, уг шашин ясаа гол болгосныг анхааралгүй орхиж болмооргүй бөгөөд үүндээ ч ихэд бодитой бодолтой хандан, энэхүү өргөн барих бичгийг нилээд төлөвлөн бэлтгэсэн болохыг тус нэгжид хадгалагдаж буй 30 гаруй тооны батлах бичгээс ойлгож болох мэт санагдана. Үүнд эцгийн нэрийг овог хэмээн ойлгож, Монгол улс нийт даяар дагах болсоны нөлөө байхыг үгүйсгэх аргагүй ч "яс угсаа", "омог" нь тэдний хувьд тухайн үед ялгаатай ойлгогдож байсан гэж болмоор байна. Өөрөөр хэлбэл дурьдсан баримтад тэд угсаа гарлыг "яс"-аар илэрхийлж, засаг захиргааны харьяаллаа "омгийн" гэгдэх нэрээр төлөөлүүлжээ. Иймээс бидний энд дурьдаж буй барга, буриад, хамнигадын адилссан омгийн тухайд судлаачдын тодорхойлсон: Овгийн /омог/ нэр нь тухайн үеийн нүүдэлч малчдын нийгмийн бүтцийн нэгжийн нэр бөгөөд энэ нь этноним биш, ураг төрлийн холбооны нэр биш, "фамилия, surname" бол бүр ч биш, үүсэл, хэвшил нь зөвхөн хүний нэртэй холбоотой биш, харин хувь хүний нэрэнд тодотгол байдлаар хэрэглэгдэж байсан нийгмийн харьцааны нэг ай юм (Цэрэнханд, Билэгт, 2003, 135) гэвэл оновчтой байж болно.

БАРГА, БУРИАДЫН ХУРИМЫН ЗАН ҮЙЛИЙН ХАМААДАЛД

Угсаа нийтлэгүүдийн ахуй соёлын адил төстэй талууд нь тэдний угсаа түүхийн нийтлэг хамаадлыг өөртөө агуулж байдаг билээ. Үүний жишээ бол монгол нутагт суурьшиж буй барга, буриадын гэр бүл болж, ураг барилдах зан заншил хийгээд түүний зарим нэг дэг ёсны төсөөтэй шинжүүд юм.

Бид, энэ хэсэгт Баргын ураг барилдах зан үйлийн үеэр гүйцэтгэдэг "хүүгэн наадуулах", "бараа хураах", "хүргэн хүү эргэж мэндлэх ёс", "инжний дуудлага ерөөл хэлэх", "бэр мөргөх" ёсыг, буриадын "басга зайлгах", "хөнжил хүргэх", "угтамж", "бэрийн засал үзэх", "бэр мөргөх" гэсэн уламжлалт заншилтай харьцуулан тэдгээрийн хоорондын адил төстэй талыг нь тодруулахыг оролдлоо. Баргын гэр бүл болох ёслол нь хүү, хүүгэний (айлд өгөгдөж буй охин, барга хэллэг) талууд харилцан зөвшилцөж, хүүгийн тал хүүгэнийг нь гуйж хадаг тавьсан тэр үеэс эхлэн, доор дурьдах зан үйлийн дагуу явагддаг учиртай. Үүнд сүй бэлэг тавих, той хурим хийх, тахил тавих, шинэ гэр төхөөрөх, хүүгэн мэдүүлэх, бэр буулгах гэсэн дараалал бүхий өөртөө тодорхой бэлэгдлийг агуулсан уламжлалууд багтдаг. Харин буриадын худ ураг барилдах ёсонд бурханд хадаг тавих, бэлэг барих, мал барих, шинэ гэр төхөөрөх, басган зайлгах, басган хүргэх зэрэг зан үйлүүд бөгөөд баргынхаас тухайн дэг ёсыг нэрлэсэн байдал, хэрэглэгдэх эд зүйлээрээ ялгагдах төдий ажээ.

Хүү, охиноо хожим гэрлүүлэхээр тохирч буриадууд нялх балчирт нь, эсвэл 10-аад настайд нь хоёр талын эцгүүд бүсээ сольж бүслэн "бүс андалдаж" /бэһэ андалдаһа/ (Басаева, 1980, 7), баргууд "өндгөн худ" болж сүй бэлэг тавьдаг уламжлалтай байж. Ингэж бүс андалдаж, өндгөн худ болсны дараагаар барга, буриад алинд нь ч, сүйн мал хөрөнгийн хэмжээг охины тал мэдэж тогтоодог байсан нь охины талыг хүндэтгэсэн бэлэгдлийг агуулсан мэт боловч цаад утгаараа төрхөм нь охиноо ямар нэг хэмжүүрээр цэгнэж, айлын болгож буй ёс юм. Энэ тухайд ... Монголчууд гаднаас эхнэр болгох бусад эмс охидыг ямар ч ялгаагүй эх эцгээс нь өндөр үнээр худалдан авмуй... (Плано Карпини, 1988, 14). ...Эрэгтэй хүн нь эхнэр болох хүнээ худалдаж авдаг ба тийнхүү худалдан авах хүртэл аав, ээж нь хүүхнээ гэртээ байлгах тул гэрлэх нас өнгөртөл гэртээ байх эмэгтэйчүүд ч байдаг... (Гильом де Рубрук, 1988, 115) гэхчлэн дундад үеийн түүхэн мэдээнд хүүхнээ худалдаж буй мэт өгүүлсэн нь үнэндээ эртний монголчуудын сүй бэлэг тавих ёс гэж болно. Энэ нь барга, буриадын худ ураг болох заншилд утга агуулгын хувьд төсөөтэй мөн чанараа алдалгүй уламжилсан ажээ.

Охиныг хадамд хүргэхээс өмнөхөн ойр төрлийнхнөөр нь зочлуулна. Үүнийг баргад "хүүгэнээ наадуулах", "хүүгэн мэдүүлэх" гэж нэрлэдэг бол буриадад "басга зайлгах" гэдэг ажээ. Баргууд энэ үеэр хадамд хүргэгдэх гэж байгаа хүүгэнээ, төрсөн эгч болон нагац талын эмэгтэйн гэрт аваачиж, малгай, цув өмсгөж, дараа нь "хүүгэн мэдүүлэх" тухай айлуудаар зар тарааж үе тэнгийн

охидуудын хамт садан төрлүүдээр нь айлчлуулах ба очсон айл нь хүүгэнийг хонины ууцаар хүндэлдэг байна (Цэрэнханд, 1987, 113). Буриадын “басган зайлгах” нь үүнтэй адил бөгөөд айлд очих гэж байгаа басган нь өвгөн түрүү, хөвүүн нөхөр хийгээд үе тэнгийн хэдэн охидын хамт өөрийн ойр төрлийн саднаар айлчилж ууц махаар дайлуулж, наадаж тоглож өнждөг байна. Бэр мордуулахаас өмнө айлд хүргэгдэх охиноо төрөл саднаар нь айлчлуулах энэ ёс ойрад монголд ч байх бөгөөд үүнийг баядад “охин чигээ уух”, дөрвөдөд “охин цайлуулах” гэж нэрлэдэг ажээ (Аюуш, 1982, 25). Ингэж охиноо ойр төрөлдөө таниулж, харьд өгөх нь ураг садныг нь мэдүүлэх гэсэн утгатайгаас гадна, энэ ёс монголчуудын дунд нийтлэг байгаа явдал бол эртний төдийгүй нэгэн уг сурвалжтай уламжлал гэдгийг харуулж буй хэрэг юм.

Буриад, баргын угсаа гарлын хамаадлыг харуулж буй өөр нэг хэрэглэгдэхүүн бол хөнжилтэй холбогдох зан үйл юм. Буриадууд басгаа хүргэх төр хуримын өмнө “хөнжил хүргэх” ёслол хийдэг. “Хөнжил хүргэх” үеэр хүүгийн талаас басганы талд хөнжил хийх арьс авчирч өгөхөд, басганы ээж тэдгээр арьсны элдэлт, чанар, хүрэх хэмжээ зэргийг сайтар нягталж үзсэний дараагаар, хүүгийн тал хөнжлийн цээжин хэсгийг, охины тал үлдэх доод хэсгийг нь оёж гүйцээдэг ажээ. Хөнжлийн дээд хэсгийг хүүгийн тал, доод хэсгийг охины тал гүйцээн оёдог нь агуулгын хувьд эцгийг хүндлэх ёсны уламжлал юм. Харин баргад үүнтэй төстэй “бараа хураах” ёслол гэж болох ба, түүнд хүүгийн ээж, хоёроос доошгүй эрэгтэйн хамт хүндтэй зочноор оролцоно. Бараа хураалганы үеэр хоёр талаас дөрөв дөрвөн нэхий арьс нэгтгэн эсгэж хүү, хүүхний хөнжлийг хамжин оёдог байна. Энэхүү ёс нь барга, буриадын алинд ч гэрлэж буй хосууд санаа сэтгэл нэгдмэл, хоорондоо эв найртай урт удаан амьдарч, ураг төрлүүд бат бэх барилдлагатай байхыг бэлэгшээсэн утгатай бололтой.

Охиныг хүргэх замд хүүгийн талаас угтаж болгоодог нэгэн ёс барга, буриадад хоёуланд адил байдаг нь зам зуурт сайн сайхан сааталгүй явж байгааг мэдэх утга аж. Үүнийг баргад “хүргэн хүү эргэж мэндлэх ёс” гэдэг бол буриадад “угтамж” гэж нэрлэдэг байна. Баргын “хүргэн хүү эргэж мэндлэх” үед, бэр хүргээчдээс түрүүлж гэртээ ирсэн хүргэн, 5-6 хүний хамтаар бэр хүргээчинд эргэн очиж, худын ах түрүү тэргүүтэй цөөн хэдтэй нь хөөрөг тамхиа солилцоод мэнд сайнаа мэдэлцээд морддог ажээ (Цэрэнханд, 1987, 114).

Буриадын “угтамж”-ийн үед, басган хадамд хүргэгдэх зам зуурт басга хүргээчдийг хүүгийн талаас худ, худгуйн түрүүтэй хэдэн хүн угтан ирж амар

мэндийг нь мэдэж, идээ унд, архи сархадаар дайлж бяцхан хүндэтгэл үзүүлдэг” номтой. Буриадын “угтамж”, баргын “хүргэн хүү эргэж мэндлэх” ёсыг бэр хүргээчдийн алжаалыг тайлж, аян замыг нь зөөллөхөөр хүүгийн талаас үзүүлж буй хүндэтгэл гэж ойлгох учиртай болуу.

Өвөг монголчуудын дунд энэ ёс байсныг өгүүлбэл, Умард Вэй (Тоба) улсын хаан Вэньди Жужаны Анагуй хааны гүнжийг хатан болгон буулгахаар тохиролцжээ. Тэгээд Вэньди хаан Фүфын, Вань Фү нарын түшмэдийг томилон, гүнжийг буулган авчруулахаар илгээжээ. Чингээд Жужаны хааны гүнжийг хүргэж яваа 700 орчим тэрэг, 10 000 орчим адуу, 1 000 тэмээ зэрэг инж бүхүй төлөөлөгчид Вэньди хааны угтуул элч нартай хоёр нутгийн заагт уулзан түр буудаллахад, Вэй улсын төлөөлөгчид Жужаны гүнжийг урьж, өөрсдийнхөө өргөөний хойморт урд зүг рүү харж суухыг хүсчээ. Гэтэл гүнж – Би одоо Вэй улсын хаанд хараахан бараалхаагүй байна. Иймд би Жужаны охин хэвээр байгаа билээ. Тиймээс би Вэй улсын ёсоор өмнө зүг харж суухгүй. Харин өөрийн ёсоор зүүн зүг рүү харж сууна гэж хэлэхэд, Вэй улсын түшмэдүүд түүний хариуд өчих үгээ олохгүй, гагцхүү журамт охин хэмээн хүндэлж, түүний үгийг зөвшөөрч байжээ (Хандсүрэн, 1994, 43). Энд өгүүлснээр, эртний жужанчуудын ёсонд бэр буулгахдаа охин янзаар нь хүргээд хойно нь эхнэр (хатан) хүний хувцас зүүтгэл өмсгөх бөгөөд нөхрийн мэдэлд бүрэн орж бараалхтал охид гүнж нарыг овог аймаг, улсын мэдэлд хэвээр байгаад тооцож байсан ажээ. Буриадын хуримын ёсонд бэрийг басган хэвээр найман салаа гэзэг, хувцас зүүтгэлтэй нь хадамд хүргэж ирсэний дараа хамган (эхнэр) хувцас өмсгөн, үсийг хоёр хагалж самнадаг нь эртний жужанчууд болон өвөг монголчуудын дээрх ёсны улбаа гэж болох юм. Энэ мэт хаад, ноёдын гүнж бэр буусан нь түүхэнд олонтаа тэмдэглэгдсэн байх тул бэрийн угтлага хүндэтгэл тэр бүрд тохиох болсоор уламжлагдан тогтсон аж. Монгол нутаг дахь эртний аймаг, улсууд сайн хөршийн эв найрыг илэрхийлэн охид гүнжээрээ гаднын аймаг улсуудад бэр буулгадаг, нөгөөтэйгүүр харийн овог, аймгаас ураг барилдахыг эрхэмлэдэг ёсноос үүдэн, хоёр талууд тодорхой нутаг газрын заагийг гарцаагүй давах учиртай болж, хүргэгдэж буй охиныг нөгөө тал өөрийн нутгийн захад хүндэтгэн угтдаг байсан нь барга, буриадын “хүргэн хүү эргэж мэндлэх ёс”, “угтамж”-ийн нэг уг сурвалж болсон бололтой. Хамниганд энэ ёсыг “угтлага” гэдэг байсан гэж болмоор байна. Тэд холоос ураг барилдахыг эрхэмлэдэг, хуримын ёслолын үеэр

⁸ Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын харьяат Няндагийн Цэцэнхүү, Балданы Идэрцэцэг нарын хуримаас бэлтгэсэн “Төр – хурим” сургалт, судалгааны баримтат кино.2003 он.

“бацаган”-ыг (“охин” гэсэн хамниган хэллэг) хүндэтгэж тодорхой нутаг зайд үдэж гаргадаг, “угтлагын хол нь сайн” гэдэг үгтэй байна. Энэ тухайд ононы хамнигадын үлгэрт: ... *Тыгээджи байхуйн үедү Джитгүлтү эзэн хоёр аягандаа араки кибэ. Хоёр цагаан хадаг царбуун дээгүүрээ табяад, Хайчилту Гайхалту хоёрай урдани гозойгоод хоёр гурба докиджи мүргөөд, үгэ кэлэджи байна: - Эркимтэ эджд – Хайчилту Гайхалту хоёр аличи болгон амараху бэй? – гэнэ. Юугиини тоорюулху байдаа. Нилуунааси шилуунни дээрэ бэдда, Хайчилан Байчилан хоёр абхай тана Болодор Мэткүлтү хоёр ахайду мана абху гэджи ирэсэн бида. Үгкүчи болбал үгкүйтана дуулайи, үгэйчи болбал үгэйги тана дуулайи! Хайчилту Гайхалту хоёр араки хадагыни абаад, үгэ кэлэджи байна: - Заа, нилээнчи хаалууд ирээ бэлэй даа, үгнэ биизэ бид даа! Та гурбайги ямар гэкү бэй? Аракиишини абаад ууджиркидаа. Тэүнээсэ хойши найр наадамай юмэ түкээрбэ даа. Найр наадам кибэ. Наен ханатай найр цагаан гэрнүүши наен наен атанда ачезлаба. Албата малайгаа тэн үрөөлэ хагасыни энджи /инж О.Б/ үгэбэ. Мордуулба даа. Мордуулаад үдэбэ хоюулаа. Угталгайн холо сайн гэлээ. – Зээ, аали нитугтаа, аян харгуйдаа мэндү күрэктүй! – гэнэ. Тыгээд лэ буцаджи очиб даа гэртээ бацагасаа үдээд лэ* ... (Жамцарано, 1982, 97) гэсэн байдаг. Буриад, барга, хамниганы “угтамж”, “хүргэн хүү эргэж мэндлэх ёс”, “угтлага” агуулга илэрхийлэлийн хувьд хүндэтгэлийг хадгалж байгаа нь ойлгомжтой юм.*

Хадамд гарч байгаа хүүгэн, басганд төрхөмүүд нь өөрсдийн хэр чадлаар хувцас хэрэглэл бэлтгэн өгч, мал инж дагуулан хүргэх нь барга, буриадад төдийгүй хамниганд ч байдгийг бид өмнөх үлгэрээс мэдсэн билээ. Энэ нь эртний улбаатай ёс юм. Ингэж бэлтгэсэн эд зүйлээ хурим найрын үед цугласан олонд мэдүүлэх учиртай бөгөөд энэ ёсыг баргад “инжний дуудлага ерөөл хэлэх”, буриадад “бэрийн засал үзэх” гэж нэрлэдэг. Баргын инжний дуудлага ерөөлд, хүүгэндээ дагуулж өгч буй номхон жороо морь, амбан шар, сааль сүү арвинтай үнээ, ноос сүү ихтэй хонь төчнөөн тоо толгойг өгснөө хөл нугалан хүндэтгэн мэдүүлэхэд хүүгэний инжинд ямаа, тэмээ багтдаггүй байна. Энэ нь монголчуудын дунд нийтлэг байх халуун хошуутай малыг эрхэмлэх ёстой холбоотой байж болох юм. Залгуулаад хүүгэнд зориулсан иж бүрэн эмээл хазаар, хударга, хүлиеэр тэрэг, мухлаг тэрэг, ханхай тэрэг, авдар сав, олбог дэвсгэр, орны ширдэг, эрээн хээтэй ор болон хүүгэний гоёл татуур, хорол

* Ц.Ж.Жамцарано /Жамсрангийн Цэвээн/ 1911 онд Ононд нутаглагч хамнигадаас нийт 6 үлгэр тэмдэглэж авсаны нэг “Болдогой чинээн болод бор моритой Болодоор эзэн”-д үүнийг өгүүлжээ. Тэрхүү үлгэрт хамнигадын ахуй соёлын байдлыг илэрхий тусгасан байдаг.

мөнгөн бэл зэргийг орц хийцтэй нь дуудан мэдүүлдэг байна (Цэрэнханд, 1987, 118, 119) Буриадын “бэрийн засал” гэдэг нь, басгандаа зориулж төрхөм талаас бэлдэж өгсөн бүх төрлийн хувцас, гоёл зүүтгэл, эд хэрэглэл, гэрийн доторх тавилга зэргийг багтаан хэлж байгаа юм. Харин басгандаа дагуулж өгсөн мал нь инж болдог байна. Бэрийн засал үзэх үеэр, цугласан олон хуримчдад бэрийн засалд орсон бүх эд зүйлсийг тоо ширхэг өнгө зүсээр нь нэрлэн дуудаж дэлгэн харуулна. Бэрийн засалд ширдэг хураадаг шургуулгатай (хугалгатай) ханз, ширээ, жирийн хүнд дэвсэх, лам хүнд дэвсэх олбог, төрөл бүрийн ширдэг, чонон хөнжил, хурган хөнжил, улирал тутмын хэдэн төрлийн хувцас, гутал, оймс, гоёл чимэглэл, зүүтгэл багтдаг байснаас гадна бүсгүй хүнийг дагаж явах учиртай “хоймрын хөгшин” гэх буриадын уламжлалт шүтээнийг нь хүртэл бэлдэж өгдөг байна. Жаран захад (дээлийг-буриадаар нэрлэсэн нь), дөчин өмдтэй бэр бууж байсан гэх бөгөөд заслын хувцсаа эзэн нь эдэлж баралгүй үе дамжуулан хэрэглэдэг байжээ. (Хэнтий, Дорнод аймагт хийсэн хээрийн судалгааны тайлан, 2003). Бэрийн засал, инж малыг өргөн олонд дэлгэн мэдүүлдэг учраас зөвхөн бэлэг төдий биш, тэр айлын ур ухаан, бэл бэнчин хэрчинээг харуулах, нэр төрийн баталгаа байсан нь барга, буриадын хуримын зан үйлд тусгалаа олсон байна.

Барга, буриадын гэрлэх ёсны өөр нэг төстэй уламжлал нь бэр мөргөх ёс юм. Бэр хадамд хүргэгдэж ирээд, хадмын гэрт орохоор явах зуураа гэрийн зүгт гурвантаа мөргөх бөгөөд тэр тоолон баргад “бэр мөргөлөө”, буриадад “бэр мөргөвэй” хэмээн өндөр дуугаар хэлнэ. Тэгж явсаар гэрийн үүдэнд ирэхэд хүүгийн тал хусан баганаар үүдээ дарж, бэрийн талынхныг хорьж зогсоох бөгөөд баганыг нь ерөөсний дараа тэднийг гэрт оруулдаг ёстой. Энэхүү тулгуур хаалт бологч баганыг монголчууд муу бүхний хаалт, хүн малын өвчин домнох, муу юмыг баганаараа айлгах, гэрийн хишиг буяныг баганаар хурайлан дууддаг... (Тангад, 1987, 49) зэрэг зан үйлд олонтоо холбогдуулах тул энэ утгаар баганыг гэрийн үүдэнд хаалт болгон барьж зогсох учиртай ажээ. Баргын бэр мөргөх үед хүү талаас:

- ... Хар хусан баганаа аван гарч
- Хаалга үүдээ даран зогсдог нь
- Хааж хорихын утга бишээ
- Хаад тэнгэрийн эрхэмлэж ирсэн
- Хаш цагаан мөнгөн үүдээ
- Эрдэнийн шүрэн баганаар дарж байсан

Эрт дээдсийн нэгэн ёсон бий

Энэнийг уламжлан айлтгаж

Ерөөлийн хэдэн үгийг сонсъюу гэх зэргээр өгүүлсний хойно хүүгэн талаас баганыг ерөөн:

Эрдэнийн чулуун баганад

Энтэй цэнхэр хадгаа өргөж

Гэрийнхээ эздэд ээлтэй байж

Гэнэтийн түгшүүрт зэвсэг болж

Нугарашгүй уян хатан

Хугарашгүй бат бэх

Үүрд мөнх үргэлж түшиг болж батжиг гэх зэргээр өгүүлдэг нь баганыг юуны учир хэрхэн хүндэтгэж ирсэн тухайд барга, буриадууд эртний уламжлалт ёсыг дагасан хэрэг болох нь. Ингэж явсаар бэр хадмын гэрт орж ирэн, эхлээд бурханд дараа нь галд гурвантаа мөргөөд хамгийн сүүлд хадам эцэгтээ өөх хаян мөргөх ёс барга, буриадад аль алинд нь байжээ. Хадам эцэгтээ өөх хаян мөргөхдөө баргын хүүгэн, гарын эрхий хурууг хонины сүүлийн халим бүхий зузаавтар нарийн өөхөөр холбосон байх үед хоёр гараараа хадам эцгийнхээ энгэр лүү өөх хаяж хормой дэвсэн өвдөглөн мөргөдөг ёстой. Буриадад, бэр гэрийн хойморт давшилж (завилаад) суусан хадам эцэгтээ гурвантаа мөргөөд модон тавагт хэрчиж хийгээд галын дэргэд тавьсан хонины сүүлийн өөхнөөс авч ам руу нь чиглүүлж чулуудна. Энэ үеэр хажуугаар зогссон олон, аавдаа мөргөвэй хэмээн тэр өөхнөөс нь авч хадам эцэг рүү нь бас шиднэ (Ц.Ханд, ага буриад, оргодой бодонгууд омог, 2003). Хадам эцэгтээ өөх хаян мөргөх ёс гадна хэлбэрээр яг адил биш ч агуулгын хувьд буриад, барга хоёуланд нь адил байсан ажээ. Энэхүү ураг барилдан гэр бүл болох ёсыг нягтлан үзвээс барга, буриадын эртний угсаа түүхийн хамаарал тэдний ахуй соёл, тэр дундаа хуримын зан үйлд илүүтэй хадгалагджээ. Учир нь ураг барилдаж гэр бүл болох үед хийдэг зан үйлийн утга агуулгыг бүрэн гүйцэд ухварлаагүй ч гэсэн хожимын учир холбогдлыг нь энгийн сэтгэхүйгээр тусган авч, чадах чинээгээрээ нэг бүрчлэн гүйцэлдүүлэх эрмэлзэл ямар ч хүний ухамсарт гүн шингэсэн байдаг. Өөрөөр хэлбэл гуйж авсан бэрийгээ ирэхэд нь хусан баганаар үүдээ даруулаад оруулахгүй байх нь энгийнээр бодоход утгагүй мэт боловч, эртний нэгэн уламжлалыг дагах төдийд муу бүхнийг хааж байдаг баганыг магтахад хүргэж, үнэндээ тэр магтаалыг хэлэхгүй бол болохгүй тийм ухамсар сэтгэхүй хүнд баттай шингэсэн байдагтай холбоотой. Тиймээс угсаатны гэр бүл болох ёс

заншил нь хуучны уламжлалт шинжээ урт хугацааны туршид хадгалах магадлал ихтэй юм. Ингэж үзвэл барга, буриадын хуримын ёс заншил тэдний угсаа-соёл, угсаа түүхийн хамаадлыг өөртөө илүү сайн хадгалж ирсэн нь дамжиггүй. Харин монгол нутаг дахь буриад, хамнигад эртнээс нааш хөрш зэргэлдээ аж төрөн сууснаар тэдний хуримын зан үйл төдийлөн ялгагдахааргүй болтол адилсахад хүргэсэн байна. Энэхүү адилсал нь өнөө үед, бидний дээр өгүүлсэн барга, буриадын хуримын зан үйлийг барга, хамниганы хэмээн орлуулан авч үзсэн ч буруудахааргүй тийм хэмжээнд очжээ. Харин өмнө өгүүлсэн баргын хуримын зан үйлийн үеэр хүргэн хүүд хүүхний талын худын түрүү:

Алтан хав загасны

Арьсыг ханзалж буцалгасан

Шар цавуугаар нааж хийсэн

Эрдэнийн цагаан энэ сумыг

Хүргэн хүү чамдаа

Түмэн бэлгийн түрүү болгож

Түшүүлэн үүнийгээ өглөө хэмээснээс үзэхэд баргууд цавуу бэлтгэхдээ аргын хувьд ... давслаагүй хулд загасны арьсыг (цавууг цааны эврээр хийж болдог байна) хуулж аван сайн гэгч хуйлаад жижиг ороомог болгон буцалж буй усанд хийж хагас цаг хэртэй чанаж болгосны дараа түүнийгээ хөргөх замаар бэлтгэсэн загасны зунгаг цавуугаар цанын улыг сайтар үрж дээгүүр нь арьс нөмөргөн наадаг (Буйлов, 1989)* цаа маллагч ортоонуудын (түнгүүсийн төрөл) аргатай адил ажээ. Баргуудын хав загас агнан арьсаар нь цавуу буцалгаж сум наадаг байсан арга нь хамниганы нэгэн төрөл ортоонуудын дунд өнөөг хүртэл хадгалагдсаар иржээ. Нөгөөтэйгүүр баргууд хамниган - түнгүүсийн адил их усны дэргэд амьдран далайн агнуур эрхлэж байсныг болон барга, хамнигадын аж ахуйн соёлын адилслыг харуулж буй бололтой.

ТАЛАРХАЛ

Өгүүллийг МУИС-ийн дэргэдэх Азийн судалгааны төвийн (ARC) төслийн хүрээнд бэлтгэн хэвлүүлэв. Дэмжлэг үзүүлсэн тус төвд талархал илэрхийлье.

* Зөвлөлт, Оросын зохиолч А.Буйлов нь 1947 онд төрсөн. 16 наснаас эхлэн 7 жилийн туршид Агнуурын тэнгисийн эрэг, Магадан мужийн ортоонуудтай цаа маллаж байсан тухайгаа болон ортоонуудын өдөр тутмын амьдралын хэв маяг, ертөнцтэй харьцах харьцаа зэргийг "Их нүүдэл" романд хүүрнэл маягаар дүрслэн үзүүлсэн нь хэдийгээр утга зохиолын төрөл бүтээл хэмээгдэх боловч бидэнд угсаатны зүйн баримт хэрэглэгдэхүүн болохуйц ажээ.

НОМ ЗҮЙ

- Аюуш Ц., 1987. Халхчуудын уламжлалт хуримын зан үйлийн асуудалд. Этнографийн судлал. т. X, fasc.1-9. 16т.
- Басаева К.Д., 1980. Буряты. Семейная обрядность народов Сибири. М.
- Батнасан Г., 1996. Буриад. МУ-ын угсаатны зүй, III боть, Ред. С.Бадамхатан нар. УБ
- Буриад - монголчуудын угсаа түүхийн зарим асуудал. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл, хэлсэн үг. Ред. Г.Гантогтох, Г.Цэрэнханд. УБ ОН
- Буйлов А., 1989. Их нүүдэл /роман/. М.
- Вандан Ю., 1875. Хорийн 11 эцгийн уг язгуурын тууж. Буриадын түүх бичиг, 1992. Улаан-Үд.
- Гаадамба Ш., 1976. Нууц товчооны нууцсаас. УБ
- Гаадамба Ш., 1990. Монголын нууц товчоо. УБ
- Гильом де Рубрук, Плано Карпини, 1988. Монголчуудын түүх. Дорно этгээдэд зорчсон минь. УБ
- Гунга Т., 1992. Балжан хатаны тууж. Буриадын түүх бичиг. Эмхэтгэсэн Ш.Чимитдоржиев. Улаан-Үд.
- Дагаар орсон буриад нарын бүртгэлүүд. Үндэсний төв архив, Фонд - 92, Данс-1, ХН - 7.
- Дашибалов Б.Б., 1995. Археологические памятники курыкан и хори. Улан- Удэ.
- Жамцарано Ц.Ж., 1982. Болдогой чинээн болод боро моритай Болодоор эзэн. Улигеры ононских хамниган. Новосибирск.
- Өлзий Ж., 1992. Барга монголын түүх. УБ
- Пунцаг А., 2000.Баргужин төхөм нутгийн овог аймгийн тухай.
- Рашид-ад-дин., 2002. Судрын чуулган. Орч.Ц.Сүрэнхорлоо. УБ
- Ринчен Б., 1967. Монгол улсын хамниган хэл аялгуу /машиндсан эх хувь/, УТА, Ф32, ХН12.
- Ринчен Б., 1979. Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас, УБ
- Сажинов Ж., 1992. Баргажаны буриадын түүхэнд хамаатай зарим зүйлүүд. Буриадын түүх бичиг. Эмхэтгэсэн Ш.Чимитдоржиев. Улаан-Үд.
- Тангад Д., 1987. Монголчуудын уламжлалт оюуны соёлын зарим асуудалд /гэрийн баганатай холбогдох ёс, зан үйлийн жишээгээр/. Этнографийн судлал, т.Х, fasc.1-9.
- Тангад Д., 1996. Хамниган. МУ-ын угсаатны зүй, III боть, Ред. С.Бадамхатан нар. УБ
- Төгөлдөр Т., 1863. Хорийн болон агын буриадуудын урд цагийн түүх. Буриадын түүх бичиг. Эмхэтгэсэн Ш.Чимитдоржиев. 1992. Улаан-Үд.
- Хандсүрэн Ц., 1994. Жужаны хаант улс, УБ
- 2002 онд Хэнтий, Дорнод аймгийн нутагт хийсэн хээрийн судалгааны тайлан, 2002. МУИС, НШУС, Угсаатан судлалын тэнхим.
- 2003 онд Хэнтий, Дорнод аймгийн нутагт хийсэн хээрийн судалгааны тайлан, 2003. МУИС, НШУС, Угсаатан судлалын тэнхим.
- Цэдэвжав С., 1887. Баргажаны буриадын түүх бичиг. Буриадын түүх бичиг. Эмхэтгэсэн Ш.Чимитдоржиев. 1992. Улаан -Үд.
- Цэжэв Ц., 1917. Баргажаны буриад зоны түүхийн товч бичиг. Буриадын түүх бичиг. Эмхэтгэсэн Ш.Чимитдоржиев. 1992. Улаан -Үд.
- Цэрэнханд Г., 1996. Барга. МУ-ын угсаатны зүй, III боть, Ред. С.Бадамхатан нар. УБ
- Цэрэнханд Г., 2001. Угсаатны онолын асуудлаар эрдэмтдийн үзэл баримтлалын тухайд. Угсаатан судлал, Ред. Г.Цэрэнханд нар. Т. XIII, fasc. 20.
- Цэрэнханд Г., Билэгт Л., 2003. "Овог" хэмээх нэр томъёоны орчин үеийн ойлголтыг судалсан урьдчилсан дүнгээс. МУИС, НШУС. Эрдэм шинжилгээний бичиг, 210 /19/.
- Цэрэнханд Г., Баттуяа О., Баатархүү Б., Ууганбаяр Б., 2003. "Төр - хурим", "Буриад зоны ахуй соёлоос" баримтат кино
- Ширабнимбуу Х., 1887. Хорийн 11 эцгийн буриад зоны түүх. Буриадын түүх бичиг. Эмхэтгэсэн Ш.Чимитдоржиев. 1992. Улаан -Үд.

ХАВСРАЛТ

Балжмаа Тэхийн - хамниган, хашха /хашхан/ омог, эм, 79 н, Дорнод, Цагаан-Овоо
Гунгаа Чойжнямын - хамниган, багш нар омог, эм, 69 н, Хэнтий, Биндэр
Даз Төмөрийн - хамниган, хар намиад омог, эр, 79 н, Дорнод, Цагаан-Овоо
Доржханд Дамчаагийн - ага буриад, баруун хуасай, эм, 79 н, Дорнод, Цагаан-Овоо
Жавхлан Майдарын - худир буриад, их чонод омог, эр, 37 н, Хэнтий, Батширээт
Доржийн Зундуйдагва - хамниган, хангис омог, эр, 84 н, Хэнтий, Дадал
Нэргүй Жамсраны - баргажин буриад, эр, 60 н, Хэнтий, Дадал
Рэнцэн Адъяагийн - барга, гүл улаан хал, эм, 84 н, Дорнод, Гурванзагал
Сумъяа Дугдамжамцын - ага буриад, хутанц шарайд омог, эр, 68 н, Дорнод, Цагаан-Овоо
Ханд Цэдэнгийн -- ага буриад, оргодой бодонгууд омог, эм, 84 н, Дорнод, Баян-Уул

SUMMARY

G.Tserenkhand, O.Battuya

ETHNOGENESIS OF BARGA, KHAMNIGAN AND BURIATS

This article is based on the Buryatian ethnographic source from XYIII- XIX c "Buryad – un teuke bicig". We compared the settlement areas, clan structure and lifestyle of barga, khamnigan and buryat ethnic groups and tried to verify the time of the barga and buryat separation and mixture and fusion of buryat and khamnigan ethnic groups.